# БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР 2022 ОНЫ ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ (ЖИЛИЙН ЭЦЭС)

2022 оны 12 дугаар 07 Улаанбаатар хот

| Шийдвэрийн дэс дугаар | Зүйл,заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц (Хэсгийн дундаж: …хувь) | Гарсан үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Засгийн газрын тогтоол | | | | | |
| 1 | 5-р заалт, 7-р заалтын 7.3 | 2021.12.22 Дугаар 388 Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | 5.Төсвийн хэмнэлтийн горимд дараахь чиглэлийг баримтлан ажиллаж, өр авлага үүсгэхгүй байх арга хэмжээ авч, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн, шууд захирагч нарт тус тус даалгасугай.<br>7.3. Орон тооны цомхтгол хийхгүй байх, одоо ажиллаж байгаа ажилчдыг үндсэн ажилтнаар шилжүүлэн ажиллуулах, ажилчдын цалин хөлс, урамшуулал, тэтгэвэрт гарахад нь хуульд заасны дагуу олгох нэг удаагийн тэтгэмжийг одоо байгаа түвшингээс бууруулахгүй олгох | 5.Тайлант жилийн батлагдсан төсвийн хүрээнд эдийн засгийн хэтрэлтгүй хэмнэлттэй ажилласан байна. Тэвчиж болох зардалуудыг хэмнэн нэн шаардлагатай байсан бусад зардалд эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн ажил үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.Өр,авлага үүсээгүй болно.<br>7.3 Бүтэц орон тооны хувьд өөрийн хүсэлтээр 3 хүн ажлаас чөлөөлөгдөж 3 хүн үндсэн ажилтнаар ажилд шинээр томилогдон ажиллаж байна. 2022 оны 12 | Өр авлага үүсгэхгүй төсвийн сахилга хариуцлагатай ажилласан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | сарын 13-ны өдрөөс 1 ажилтан чөлөөлөгдөн гавъяаны амралтандаа гарч байгаа тул батлагдсан төсвийн хүрээнд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгогдоно.Хэрэгжилт 80 хувь | |
| 2 | 1 дүгээр заалт | 2022.03.02 №02 Шилэн дансны тухай хууль журмыг хэрэгжүүлэх тухай | Шилэн дансны тухай хууль журмыг хэрэгжүүлж, шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээллийг үнэн зөв тогтмол байршуулах ажлыг хэвшүүлж ажиллахыг нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай. | Ил тод байдлын хуулийн хэрэгжилтийн хүрээнд Шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв тогтмол байршуулан ажилласан. Хуулийн хугацаанд нийт өссөн дүнгээр 136 мэдээг байршуулан тайлан илгээсэн байна. Хугацаа хоцорч мэдүүлсэн болон дутуу мэдүүлсэн мэдээ, тайлан байхгүй байна. Хэрэгжилт 50 хувь | Хуулийн хэрэгжилт хангагдсан. |
| **ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ** | | | | | |
| 3 | 1 дүгээр заалт | 2022.02.22 №65 Журам батлах тухай | 2-р заалт: Өмч хамгаалах Байнгын көвлөл байгуулж үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай. | Байгууллагын даргын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/04 тоот тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг шинэчлэн байгуулж дүрмийг шинэчлэн баталсан.Хэрэгжилт 50 хувь | Өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулсан. |
| НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ | | | | | |
| 4 | 1.1 дүгээр заалт | 2022.02.16 Дугаар 03 | 1.1 Засгийн газар, Улсын онцгой комиссоос Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт | Халдвар хамгааллын дэглэмийг сахиж, амны хаалт тогтмол зүүж, гараа | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | шилжүүлсэн хугацааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн цуцалж, халдварын тархалтын “Шар түвшинд” шилжсэнтэй холбогдуулан “Коронавируст халдвар (ковид-19)-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасныг баримтлан халдвар хамгааллын дэглэмийг сахиж, амны хаалт тогтмол зүүж, гараа ариутган, дархлаа сэргээх нэмэлт тунд ажилчдаа бүрэн хамруулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын уриалж ажиллах | ариутган, дархлаа сэргээх нэмэлт тунд ажилчдаа бүрэн хамруулсан.<br>Хэрэгжилт 80 хувь | |
| 5 | 9.1 дүгээр заалт | 2022.10.14<br>№03 | 10.1 Нийслэлийн агаар орчны бохирдол, өвөлжилтийн бэлтгэл ажил, сайжруулсан шахмал түлштэй холбоотой гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн зохион байгуулалттай хамтран ажиллах | Байгууллагын даргын баталсан “Сайжруулсан түлшний хяналт хийх” хуваарь удирдамжийн дагуу томилогдсон нэр бүхий 6 албан хаагч 2022 оны 01 дүгээр сард СБД-ийн 19-р хорооны хэсгийн ахлагч нар болон Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын байцаагчдын хамтаар Санзай, Хандгайт, Майхан толгой, Баянбулаг, Шар морьтын хэсгийн айл өрх, ахуйн нэгжүүдээр орж, зөвлөгөө өгч ажилласан.<br>Хэрэгжилт 50% | |
| **НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ** | | | | | |
| 6 | 2 дугаар заалт | 2022.04.27<br>Дугаар А/578 | Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ) –ийг цуглуулахад үндэслэл болгосон дүрэм, журмыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай | Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ы | Мэдээллийн аюулгүй байдал хангагдана. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Ажлын хэсэг байгуулах тухай | нийцүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулж, тайлагнахыг нийслэлийн харьяа бүх шатны байгууллагын дарга нарт үүрэг болгосугай. | өдрийн 10/555 тоот албан бичиг болон мөн өдрийн Албан хаагчдад хяналт шалгалт хийсэн тухай зөвлөмжийн дагуу байгууллагад ZKTeco нэртэй камертай нүүр болон хуруу таниулах 2 төхөөрөмжийг авч өнөөдрийг хүртэл ашиглаж байна. Тус 2 төхөөрөмжинд нийт 10 албан хаагчийн хурууны хээ бүртгэлтэй байсныг устган зөвхөн нүүр таниулахаар болгон тохируулсан байна. Нийслэлийн мэдээлэл технологийн газарт хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргүүлж ажилласан.100% | |
| 7 | 5 дугаар заалт | 2022.06.09 А/789 Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай | 5-р заалт:Дуудлага үйлчилгээний автомашиныг өдрийн 40 км-ээс хэтрүүлэхгүйгээр ашиглаж байхаар тогтоосугай. | Нийслэлийн төр захиргааны авто баазтай гэрээ шинэчлэн байгуулан журмын хэрэгжилтийг мөрдөн ажиллаж байна.<br>2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн нийслэлийн Төр захиргааны Авто баазаас зохион байгуулсан сургалтанд цахим хамрагдсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | 1 дүгээр заалт | 2022.08.15 Дугаар А/1049 Журам шинэчлэн батлах тухай | 1.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг хавсралтаар баталсугай. | Шинэчлэн батлагдсан журмыг өргөдөл гомдол шийдвэрлэх үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна. Хэрэгжилт 50% | |
| НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ | | | | | |
| 9 | 1 дүгээр заалт | 2022.10.07 Дугаар 16 | 1.Иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, зөрчил гаргасан, тайлан мэдээг, дээд шатны байгууллагад тайлагнаж ажиллаагүй, албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллахыг нутгийн захиргааны байгууллагуудад | 2022 оны жилийн эцсийн байдлаар өргөдөл гомдлын системд нийт 4 өргөдөл, хүсэлт бүртгэгдсэн. Өргөдлийг хүлээн авч удирдлагад танилцуулан шийдвэрлэлтийг ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэсэн. Хугацаа хоцроож шийдвэрлэсэн, буюу өдөрт нь нээж хараагүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй гэх мэт зөрчил байхгүй. Хэрэгжилт 70% | Хуулийн хэрэгжилт хангагдна. |
| ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ | | | | | 64% |